



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/169

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдсэн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар” Ховд аймгийн ногоон хөгжлийн /2016-2026/ хөтөлбөр”, “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан “Аймгийн ерөнхий агнуурын зохион байгуулалтын судалгаа хийх” ХООНӨГ/201700017 дугаартай гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгоход зориулан 2 998 500 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 2 998 500 төгрөг /хоёр сая есөн зуун ерэн найман мянга таван зуун/-ийг аймгийн байгаль хамгаалах сангийн 4.3-д тусгагдсан “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлого зорилтыг хэрэгжүүлэх” арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 Зах А/169 Гн 00769